

**ХҮН ХУДАЛДААЛАХТАЙ ТЭМЦЭХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ДЭД ЗӨВЛӨЛИЙН
2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хүрэх түвшин	Хариуцах этгээд	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Биелэлт	Үнэлгээ
Нэг. Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр						
1.1	Хүн худалдаалахтай тэмцэх чиглэлээр авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардлыг 2026 оны улсын төсөвт тусгуулж, батлуулах	Улсын төсөвт тусгасан эсэх	ГХУСАЗЗАА	Сангийн яам	ГХУСАЗЗАА-ны даргын 2025 оны А/07 болон А/12 дугаар тушаалаар “Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд бараа, үйлчилгээ нийлүүлэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороо”-г байгуулсан. Үнэлгээний хорооноос Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд худалдан авах ажиллагааг зохион байгууллаа. Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд бараа, үйлчилгээ нийлүүлэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороо 2025 оны 03 дугаар сарын 11-нээс 05 дугаар сарын 20-ны өдрийн хооронд нийт 8 удаагийн хурлыг зохион байгуулж, нийт 144,932,480 (нэг зуун дөчин дөрвөн сая есөн зуун гучин хоёр мянга дөрвөн зуун наяд) төгрөгийн худалдан авах ажиллагааг амжилттай зохион байгууллаа. Тухайлбал, 1.Хүйсийн тэгш эрх төв төрийн бус байгууллагатай 30,000,000 (гучин сая) төгрөгийн үйлчилгээ үзүүлэх; 2.Мед импекс ХХК-тай 41,118,000 (дөчин нэгэн сая нэг зуун арван найман мянга) төгрөгийн бараа худалдан авах; 3.Антиген ХХК-тай 41,000,000 (дөчин нэгэн сая) төгрөгийн бараа худалдан авах;	100

					4.Би си ти ХХК-тай 32,814,480 (гучин хоёр сая найман зуун арван дөрвөн мянга дөрвөн зуун ная) төгрөгийн худалдах, худалдан авах гэрээ тус тус хийгдсэн байна. Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр 2026 онд шаардагдах төсвийн талаарх саналыг ХЗДХЯ-аар дамжуулан Сангийн яаманд хүргүүлсэн. Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр 142,986,100 төгрөгийн төсөв тавигдсан нь 2025 онтой харьцуулбал 41 хувиар буурсан үзүүлэлт байна.	
1.2	Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхдэд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журмыг боловсруулах (ХХТХ-ийн 5.2.4)	Журам батлагдсан эсэх	ГБХНХЯ, ХЗДХЯ	-	Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх салбар дундын хамтарсан багаас “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхдэд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам”, “Салбар дундын хамтарсан багийн бүрэлдэхүүн, ажиллах журам”-ын төслийг боловсруулж, Хууль зүй, дотоод хэргийн яам, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд тус тус хүргүүлсэн.	70
1.3	Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхдэд үйлчилгээ үзүүлэх салбар дундын хамтарсан багийг байгуулж, ажиллах журмыг батлуулах (ХХТХ-ийн 5.2.5)	Журам батлагдсан эсэх	ХЗДХЯ	ГХУСАЗЗАА	Дээрх журмын төслийг 2025 оны 07 дугаар сард цахим хуудсанд байршуулан олон нийтээс санал авлаа. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн А/156 дугаар тушаалаар “Салбар дундын хамтарсан багийн бүрэлдэхүүн, ажиллах журам”-ыг баталлаа.	100
1.4	Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн аюулгүй байдлыг хангах түр хамгаалах байрны стандартыг шинэчлэн боловсруулах	Стандартын төслийг шинэчлэн боловсруулсан эсэх	ГБХНХЯ	Холбогдох эрх бүхий байгууллага	Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн аюулгүй байдлыг хангах, түр хамгаалах байранд тавигдах нийтлэг шаардлага стандартын төслийг Хүүхдийн хөгжил, хамгааллын стандартчиллын техникийн хорооны 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 02 дугаар хуралдаанаар хэлэлцлээ.	100

	(ХХТтХ-ийн 9.6)				Дээрх стандартыг Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2025 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн С/54 дүгээр тушаалаар баталсан байна.	
1.5	“Хүүхдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх журам”-ын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, шинэчлэн боловсруулах (ХХТтХ-ийн 5.8, МУИГХХЗЦтХ-ийн 7.4)	Журмыг шинэчлэн боловсруулсан эсэх	ХЗДХЯ, ГХУСАЗЗАА	ХХЕГ, ЦЕГ, БЕГ	Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Хүний эрхийн багц хуулийн төслийг Хүний эрхийг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр Улсын их хуралд өргөн мэдүүлсэн. Монгол Улсын иргэнийг Монгол Улсын хилээр гарах эрхийг түдгэлзүүлэх журмыг боловсронгуй болгох, хилийн хориг тавих эрх бүхий байгууллагуудын уялдаа холбоог хангах, сайдын шийдвэрээр зохицуулж байсан хүүхдийг хилээр нэвтрүүлэх журмыг хуулиар зохицуулах зорилготой Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл уг төсөлд багтсан байна. ГХУСАЗЗАА-аас “Дэлхийн зөн Монгол” олон улсын байгууллага, “Анбаунд Монгол” ТББ хамтран Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/49 дүгээр тушаалаар баталсан “Хүүхдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхэд хяналт тавих журмын хэрэгжилт: асуудал-шийдэл” хэлэлцүүлгийг 2025 оны 01 дүгээр сарын 09, 10-ны өдрүүдэд Дорноговь аймгийн Замын-Үүд суманд үйл ажиллагаа явуулдаг цагдаа, хил хамгаалал, гадаадын иргэн, харьяат, гаалийн байгууллагын нийт 42 төлөөллийг оролцуулан зохион байгууллаа. Панел хэлэлцүүлэгт Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын цагдаагийн хэлтсийн	90

					Эрүүгийн ахлах мөрдөгч Цагдаагийн хошууч Б.Мягмарсүрэн, Хил хамгаалах ерөнхий газрын Шалган нэвтрүүлэх хэлтсийн ахлах офицер, дэд хурандаа Э.Мөнхцог, Дорноговь аймгийн Замын-Үүд сумын автозамын боомтын Шалган нэвтрүүлэх тасгийн ахлах ажилтан Тулгабат, Замын-Үүд сумын ГБХЗХ-ийн хэлтсийн Нийгэм бодлогын хариуцсан дарга С.Оюунчимэг, Анбаунд Монгол ТББ-ын төслийн ажилтан Ц.Цэцэгбадам нар оролцлоо. Тус Ажлын албанаас Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/49 дүгээр тушаалаар баталсан “Хүүхдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхэд хяналт тавих журмын хэрэгжилт: асуудал-шийдэл” хэлэлцүүлгийг мөн оны 02 дугаар сарын 06-ны өдөр Хууль зүй, дотоод хэргийн яам, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам, Цагдаагийн ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, Боловсролын ерөнхий газар, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар, Соёл, урлагийн газар, Монголын Нотариатчдын танхим, “Анбаунд Монгол” ОУБ-ын төлөөллийг оролцуулан зохион байгууллаа. Хэлэлцүүлгээс гарсан үр дүнг Хууль зүй, дотоод хэргийн сайд бөгөөд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн даргаас өгсөн чиглэлийн дагуу холбогдох хууль болон журамд өөрчлөлт оруулах саналтайгаар Хууль зүйн бодлогын газарт 2025.02.21-ний өдөр хүргүүлээ. Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь төслийн хүрээнд Анбаунд Монгол ТББ-аас 2025 оны 12 дугаар сарын 02-ны өдөр зохион байгуулсан Хил	
--	--	--	--	--	---	--

					дээрх дамжин өнгөрүүлэх ажиглалтын тайлангийн хурлыг зохион байгууллаа. Тайлангийн хурлаар Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/49 дүгээр тушаалаар баталсан Хүүхдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхэд хяналт тавих журмын хэрэгжилт, хил дээрх дамжин өнгөрүүлэх ажиглалтын үр дүнгийн талаарх мэдээллийг танилцууллаа. Улсын бүртгэлийн байгууллагаас гадаад улсах зорчих 16-аас доош насны хүүхдэд Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсэгт заасныг үндэслэн олгож байна. Хил хамгаалах ерөнхий газраас Монгол Улсын хилээр 2025 оны 01 дүгээр сарын 01-нээс 11 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаанд нийт 695,025 (орсон-349,840 гарсан-345,187) хүүхдийг шалган нэвтрүүлсэн. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд заагдсан чиг үүргийн хүрээнд эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчгүй болон тэдний итгэмжлэлгүйгээр хилийн боомтод ирсэн нийт 59 хүүхдийг “Хүүхдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхэд хяналт тавих журам”-ын дагуу улсын хил нэвтрүүлэлгүй буцааж, Цагдаагийн байгууллагаас олгосон зөвшөөрөлтэй 16,864 хүүхдийг улсын хилээр шалган нэвтрүүлж, хилийн чандад үлдсэн 2409 хүүхдийн буцаж ирээгүй шалгаан тогтоон ажилласан. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/49 дүгээр тушаалаар батлагдсан "Хүүхдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхэд хяналт тавих журам"-ын 2.1.4 дэх заалтыг хэрэгжүүлэх,	
--	--	--	--	--	--	--

					сурталчлах ажлын хүрээнд олон улсын уралдаан, тэмцээн, урлаг соёлын арга хэмжээнд оролцох болон сурагч, оюутан солилцоогоор суралцах хүүхдэд Цагдаагийн байгууллагын зөвшөөрлийг үндэслэн нислэгийн тийз олгож, хамтран ажиллах талаарх албан бичгийг агаарын тээвэрлэгч компани (дотоодын 4, гадаадын 11)-д хүргүүлсэн. “Хүүхдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхэд хяналт тавих журам”-ыг контент байдлаар олон нийтэд сурталчлах ажлыг Хилийн цэргийн 0218 дугаар ангитай хамтран "Хилчин хүү, Шалгагч охин" сэдэвт контентыг Хил хамгаалах байгууллагын цахим хуудсаар дамжуулан олон нийтэд хүргэсэн. Цагдаагийн байгууллагаас “Хүүхдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхэд хяналт тавих журам”-ын 2.1.4 дэх хэсэгт заасан “Олон улсын уралдаан тэмцээн, урлаг соёлын бусад арга хэмжээнд оролцуулах бол хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий цагдаагийн байгууллагын нэгжийн /зөвшөөрөл/” авах заалтын хүрээнд 2025 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн байдлаар Монгол Улсаас гарах чиглэлд насанд хүрээгүй хүүхдийг олон улсын уралдаан тэмцээн, урлаг соёлын бусад арга хэмжээнд оролцуулахаар зөвшөөрөл хүссэн 1031 байгууллагын 11043 хүүхдийн материалыг хүлээн авч, хянаж, шалгах ажиллааг явуулан зөвшөөрөл олгосон. Анбаунд Монгол ТББ-аас “Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь” төслийн хүрээнд 2025 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр Дорноговь	
--	--	--	--	--	---	--

					аймгийн Замын-Үүд суманд Хүүхдийг Монгол улсын хилээр нэвтрүүлэхэд хяналт тавих журмын талаарх хэлэлцүүлгийг хамтран зохион байгууллаа. Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт “Хүүхдийг хүн худалдаалахаас хамгаалах нь” төслийн хүрээнд Алтанбулаг хилийн авто замын боомтод Дамжин өнгөрөх ажиглалтын үйл ажиллагааг хэрэгжүүлж эхэлсэнтэй холбогдуулан 2025 оны 5 дугаар сарын 29-ний өдөр “Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд хамтын ажиллагааг бэхжүүлэх нь” уулзалтыг Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумд зохион байгуулсан. Тус уулзалтад Хилийн цэргийн 0101 дүгээр анги, Сэлэнгэ аймгийн Цагдаагийн газар, Сэлэнгэ аймаг дахь Гаалийн газар, Сэлэнгэ аймгийн Засаг даргын тамгын газар, Алтанбулаг сумын Засаг даргын тамгын газар, ГИХГ-ын Хойд бүс дэх газрын нийт 35 төлөөлөл оролцож хүн худалдаалах гэмт хэргийн өнөөгийн нөхцөл байдал болон Дамжин өнгөрөх ажиглалтын үйл ажиллагааны талаар мэдээлэл авч санал солилцсон.	
1.6	Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид эрүүл мэндийн нөхөн сэргээх эмчилгээ болон сэтгэцийн нөхөн сэргээх эмчилгээ үйлчилгээ үзүүлэх журмыг шинэчлэн батлах (ХХТХ-ийн 5.5.1)	Журам батлагдсан эсэх	ЭМЯ		Журмын төсөл боловсруулагдсан. Харъяа байгууллагуудаас санал авч байна.	0
1.7	Түр хамгаалан байрлуулах үйлчилгээний нэг хүнд ногдох хувьсах зардал	Журмыг шинэчлэн боловсруулсан эсэх	ГБХНХЯ	ХГБХХЕГ	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас түр хамгаалан байрлуулах үйлчилгээний нэг хүнд ногдох хувьсах зардал тооцох журмыг шинэчлэн боловсруулж, 2025 оны	70

	тооцох журмыг шинэчлэн батлуулах				10 дугаар сарын 15-ны 05/3301, 05/3302 тоот албан бичгээр журмын төсөлд 39 түр хамгаалах байр болон нэг цэгийн үйлчилгээний төвүүдээс холбогдох санал авч саналыг тусгасан. ГБХНХЯ-ны сайтад 2025 оны 10 дугаар сарын 21-ний өдөр санал авахаар https://mlsp.gov.mn/content/detail/3823 нээлттэй байршуулсан. Ирсэн саналыг тусган саналын товъёог бэлтгэн журмын төслийг албажуулахаар ажиллаж байна.	
1.8	Хүн худалдаалахтай тэмцэх дунд хугацааны төлөвлөгөөг батлуулах (ХХТтХ-ийн 5.1.1)	Төлөвлөгөө батлагдсан эсэх	ГХУСАЗЗАА	Дэд зөвлөлийн гишүүд	Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх дунд хугацааны төлөвлөгөөний төслийг эцэслэн боловсруулж дууссан. Эдийн засгийн тооцоолол хийх ажил хүлээгдэж байгаа бөгөөд энэ ажил 2025 оны II хагас жилд хийхээр төлөвлөгдсөн.	50
1.9	Олон улсын байгууллагаас хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэх (ХХТтХ-ийн 5.1.2)	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт	ОУБ	Дэд зөвлөлийн гишүүд	Монгол Улсын Засгийн газар болон Америкийн Нэгдсэн Улсын Төрийн департаментын байгуулсан “Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь” төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан дараах ажил арга хэмжээг зохион байгууллаа. Үүнд: 1.Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь хилийн хяналтын байгууллагын албан хаагчдад зориулсан Хүн худалдаалах гэмт хэргийн ойлголт, Хүүхдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхэд баримтлах журмын талаарх сургалтыг 2025 оны 01 дүгээр сарын 09, 10-ны өдрүүдэд зохион байгуулж, нийт 123 (эр-72, эм-51) албан хаагчийг хамруулав. 2.Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх дэд зөвлөлийн дэргэд ажилладаг	100

					Салбар дундын хамтарсан багийн ээлжит хурлыг 3 удаа зохион байгуулсан. Хуралдаанаар хүн худалдаалах гэмт хэргийн нөхцөл байдал, шинээр бүртгэгдэж буй хүн худалдаалах гэмт хэргийн онцлог зэргийн талаар мэдээлэл солилцож, Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсантай холбоотойгоор Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд нэмэлтээр орсон "Салбар дундын хамтарсан багийн ажиллах журам", "Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхдэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам"-ын төсөлтэй танилцаж, журмуудын уялдаа холбоог нь хангах, хуульд тодорхой заагаагүй зохицуулалтуудыг нэмж тусгалаа. Түүнчдэн дээрх журмын төслүүдийг ХЗДХЯ, ГБХНХЯ-ны цахим хуудсанд байршуулж, олон нийтээс санал авлаа. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхдэд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх салбар дундын хамтарсан багийн ажиллах журам, бүрэлдэхүүнийг Хууль зүй, дотоод хэргийн сайдаар батлуулахаар танилцууллаа. 3. "Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь" төслийн хүрээнд "Улаанбаатар төмөр зам" ХНН-ийн Зорчигч тээврийн албаны албан хаагчдын хүн худалдаалах гэмт хэргийн талаарх мэдлэг, ойлголтыг нь дээшлүүлэх зорилгоор "Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг таньж, илрүүлэх нь" сургалтыг энэ сарын 28-30-ны өдрүүдэд зохион байгуулж УБТЗ ХНН-ийн Зорчигч тээврийн албаны 150 гаруй албан хаагч хамрууллаа.	
--	--	--	--	--	--	--

					4.Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч төвтэй, хүүхдэд ээлтэй форензик ярилцлагын арга зүй” сэдэвт сургалтыг 2025.06.16, 17-ны өдрүүдэд зохион байгуулж, сургалтад Мөрдөн байцаах албаны Хүүхдийн эсрэг болон хүүхдээс үйлдсэн гэмт хэргийн мөрдөх хэлтэс, Кибер гэмт хэрэгтэй газар, төв, орон нутгийн цагдаагийн газрын хүүхдийн гэмт хэрэг мөрдөх чиг үүргийн 138 албан хаагчийг хамрууллаа. 5.“Кибер орчныг ашиглаж үйлдсэн хүн худалдаалах гэмт хэрэг (ХХГХ)-ийн мөрдөн шалгах ажиллагаа” бүсийн сургалтыг 2025 онд зохион байгуулж, нийт 356 (эр-277, эм-79) мөрдөгч, прокурорыг хамрууллаа. 6.2025 оны 06 дугаар сарын 26, 27-ны өдөр Баян-Өлгий аймгийн хилийн боомтын байгууллагуудын албан хаагчдад зориулсан “Хүн худалдаалах гэмт хэргийн ойлголт, онцлог” сургалтыг зохион байгуулж, хүн худалдаалах гэмт хэргийн нөхцөл байдал, чиг хандлага, урьдчилан сэргийлэх, илрүүлэх, хилийн боомтуудын өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага, Монгол Улсын хилээр хүүхэд нэвтрүүлэхэд анхаарах асуудал болон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хэрэглэсэн хүнд илрэх шинж тэмдгийн талаар ойлголтын талаар мэдээлэл өглөө. Сургалтад нийт 36 (эр-24, эм-12) алба хаагч хамрагдлаа. 7."Хилийн боомтын байгууллагын алба хаагчдыг чадавхжуулах" сургалтыг 2025 оны 08 дугаар сарын 17-ны өдөр Өмнөговь аймгийн	
--	--	--	--	--	---	--

					Гашуунсухайт боомтод зохион байгуулж, хилийн хяналтын байгууллагын 68 алба хаагчийг хамрууллаа. Сургалтаар хүн худалдаалах гэмт хэргийн тухай ойлголт, чиг хандлага, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үйл ажиллагаа, хүүхдийн эрх, хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, хил дээрх дамжин өнгөрүүлэх ажиглалтын үйл ажиллагаа болон хүүхдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхэд баримтлах журмын хэрэгжилтийн талаар тус тус мэдээлэл өглөө. 8.Өмнөговь аймгийн Цагдаагийн газартай хамтран аймгийн хууль сахиулах, хил хамгаалах, нийгмийн хамгаалал, боловсрол, соёл урлаг, эрүүл мэндийн байгууллагын албан хаагчдад зориулсан сургалтыг 2025 оны 08 дугаар сарын 18-ны өдөр зохион байгуулж, нийт 68 алба хаагчийг хамрууллаа. 9.Жил бүрийн 7 дугаар сарын 30-ны өдөр зохион байгуулдаг Хөх зүрхний аяныг зохион байгуулж, хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар иргэд олон нийтэд мэдээ, мэдээлэл түгээлээ. 10. Хүн худалдаалах болон хүүхдээр тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэхээс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх "Мөрөөдлийнхөө зүг" кампанит ажлыг 2025 оны 11 дүгээр сарын 24-ний өдрөөс 12 дугаар сарын 24-ний өдрийн хооронд зохион байгуулж байна. 11. Хүн худалдаалах гэмт хэргийн хянан шийдвэрлэх ажиллагаа: Асуудал-шийдэл	
--	--	--	--	--	--	--

				хэлэлцүүлгийг 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдөр зохион байгууллаа. Хэлэлцүүлгээр хүн худалдаалах гэмт хэргийн нөхцөл байдлын талаарх мэдээллийн сонсохын зэрэгцээ хүүхдэд ээлтэй, хохирогч төвтэй, сэтгэцийн гэмтэлд суурилсан Форензик ярилцлагын аргыг нэвтрүүлэх талаар хэлэлцүүлэг өрнүүллээ. 12.УЕПГ, Азийн сан, Хүйсийн тэгш эрх төв хамтран 2025 оны 09 дүгээр сарын 17, 25, 26-ны өдрүүдэд Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийг даган гарсан шинэ журам болон шинэчлэн найруулан батлуулсан журмыг танилцуулах, нийгмийн хамгааллын алба хаагч, мэргэжилтнүүд болон эрүүл мэндийн салбарын асуудал хариуцсан 150 мэргэжилтний ур чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн сургалтыг зохион байгууллаа. 13.Төслийн хүрээнд Эрүүгийн цагдаагийн албаны хүн худалдаалахтай тэмцэх нэгжийн үйл ажиллагаанд шаардлагатай Sumbee програмыг нэвтрүүлж, дэмжлэг үзүүллээ. НҮБ-ын Олон улсын хөдөлмөрийн байгууллагатай хамтран хэрэгжүүлж буй Бриж-2 төслийн хүрээнд Шүүх эрх мэдэл, хууль сахиулах байгууллагын албан хаагчдад зориулсан албадан хөдөлмөрийг таньж илрүүлэх сургалтын гарын авлагыг боловсруулж дууслаа. Сургалтын гарын авлагыг Шүүхийн академийн сургалтын хороогоор 2025 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр хэлэлцүүлэн батлуулсан.	
Хоёр. Хүн худалдаалах гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг судлах, урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын хүрээнд					

2.1.	“Хүн худалдаалахын төлөв байдал-2024” судалгаа хийх (ХХТтХ-ийн 6.6.2)	Судалгааны тайлан гарсан эсэх	Салбар дундын хамтарсан баг	Дэд зөвлөлийн гишүүд	Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх салбар дундын хамтарсан багаас Хүн худалдаалах төлөв байдал-2024 судалгааны ажлыг хийж гүйцэтгэлээ. Судалгааны багт УЕПГ, ТББ-ын төлөөлөл ажилласан. Судалгааны үр дүнг 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдөр зохион байгуулсан Хүн худалдаалах гэмт хэргийн хянан шийдвэрлэх ажиллагаа: Асуудал-шийдэл хэлэлцүүлгийн үеэр танилцуулж, www.cccp.gov.mn цахим хуудсанд байршууллаа. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд хүн худалдаалах гэмт хэрэг ял шийтгэгдсэн 25 (эрэгтэй-14, эмэгтэй-11), бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэгт 15 (эрэгтэй 9, эмэгтэй-6) хүн ял эдэлж байна.	100
2.2	“Албадан хөдөлмөрлүүлэх болон түүнтэй төстэй гэмт хэргийн нөхцөл байдал” судалгаа хийх (ХХТтХ-ийн 6.6.2)	Судалгааны тайлан гарсан эсэх	УЕПГ	УДШ, ГХУСАЗЗАА	“Албадан хөдөлмөрлүүлэх болон түүнтэй төстэй гэмт хэргийн нөхцөл байдал”-ыг судлах судалгааг 2022-2024 оны байдлаар мөрдөн шалгах ажиллагаа явуулсан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.13 дугаар зүйл “Албадан хөдөлмөрлүүлэх”, 16.1 дүгээр зүйл “Хүүхдийг гэмт хэрэг үйлдэхэд татан оруулах”, 16.4 дүгээр зүйл “Хүүхдээр гуйлга гуйлгах”, 16.8 дугаар зүйл “Хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах”, 16.9 дүгээр зүйл “Хүүхэд оролцуулж садар самууныг сурталчлах”, 16.10 дугаар зүйл “Хүүхдээр тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэх” гэмт хэргийг хамруулан хийлээ.	100

					Судалгааны багт Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын газар, ГХУСАЗЗАА-ны төлөөлөл орж ажилласан. Судалгааны үр дүнг 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдөр зохион байгуулсан Хүн худалдаалах гэмт хэргийн хянан шийдвэрлэх ажиллагаа: Асуудал-шийдэл хэлэлцүүлгийн үеэр танилцуулж, www.cccp.gov.mn цахим хуудсанд байршууллаа.	
2.3	Хүн худалдаалах гэмт хэрэгт өртөж хохирсон иргэдтэй уулзалт, ярилцлага хийх замаар энэ төрлийн гэмт хэрэгт өртсөн иргэдийг таних, туслалцаа үзүүлэх, хамгаалах талаар судалгаа хийх	Судалгааны тайлан эцэслэгдэж, холбогдох байгууллагад танилцуулсан эсэх	ТЕГ	ЦЕГ, ТББ	Тагнуулын байгууллага нь хүн худалдаалах гэмт хэрэгт өртөж хохирсон иргэдийг таних, туслалцаа үзүүлэх, хамгаалах талаар судалгаанд хамрагдах 20 орчим охид, эмэгтэйчүүдийг ЦЕГ болон төрийн бус байгууллагаар дамжуулан уулзалт зохион байгуулж, цуглуулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийлээ. Түүнчлэн хүн худалдаалах, бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн хохирогч болж байсан иргэдийн өмнө нь өгч байсан тайлбар, мэдүүлэг, нөхцөл байдал зэрэг мэдээлэлд судалгаа хийн дүн шинжилгээний аргаар боловсруулалт хийлээ. ХТЭТ ТББ-аас Сьерра Леон улсын 7 иргэн албадан хөдөлмөрт өртсөн байж болзошгүй мэдээллийн дагуу холбогдох үйлчилгээ үзүүлэн, өмгөөлөл, орчуулгын туслалцаа үзүүлж, холбогдох төрийн болон ОУ-ын байгууллагуудтай хамтран ажиллаж байна. 2025 оны 3 сарын 25-наас 6 сарын 25-ны хооронд, АНУ-ын Лотус сангийн тэтгэлгээр хамгаалах байранд 8 хохирогчийг байрлуулан хамгаалж, гадуур үйлчилгээний хүрээнд бэлгийн мөлжлөгийн 5 хохирогчид сэтгэл зүй, хууль, нийгмийн үйлчилгээний дэмжлэг үзүүлэн	80

					ажиллаж байна. Мөн 3 насанд хүрээгүй хохирогч хүүхэд барьцаалагдан, эцэг эх нь хөдөлмөр мөлжлөгт өртсөн байж болзошгүй мэдээллийн дагуу холбогдох хууль, төрийн байгууллагуудад хандан ажиллаж байна. ГХУСА33АА-аас зарласан тендерт шалгарч, хохирогчдод туслалцаа үзүүлэх ажлаа үргэлжлүүлэн, 11 хохирогчид эрүүл мэнд, сэтгэлзүй, хуульзүй, анхан шатны хэрэгцээний шууд туслалцаа, үйлчилгээ үзүүлж байна. Анбаунд Монгол ТББ-аас 2025 оны 1-5 дугаар сарыг дуустал Дорноговь аймгийн Замын-Үүд авто замын хилийн боомтод, Сэлэнгэ аймгийн Алтанбулаг авто замын боомтод тус тус Дамжин Өнгөрөх Ажиглалтыг тасралтгүй хэрэгжүүлж нийт эрсдэлд байж болзошгүй 2718 (Замын үүд 2687, Алтанбулаг 31) зорчигчдоос аяллын аюулгүй байдлын асуулга авч тэдэнд хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээлэл өгсөн бөгөөд нийт 21 зорчигч аяллаа зогсоон туслалцаа, үйлчилгээ авсан.	
2.4	Цахим орчинд хүн худалдаалах, бэлгийн мөлжлөг, биеэ үнэлэхийг зохион байгуулж буй цахим хуудсуудыг илрүүлэх, таслан зогсоох (ХХТХ-ийн 5.7)	Үйл ажиллагааг нь зогсоосон цахим хуудас	ЦХИХХЯ, ЦЕГ	ХХЗХ	Тагнуулын байгууллагаас эмэгтэйчүүдийг элсүүлэн, шан харамж өгөх байдлаар цахим сүлжээ ашиглан биеийг нь үнэлүүлэх, улмаар Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улс, БНХАУ-ын Эрээн болон Хөх хот, БНХАУ-ын Засаг Захиргааны Онцгой бүс Макао зэрэг улс, хотод худалдаалах ажлыг гүйцэтгэдэг, зохион байгуулдаг иргэн "Ц", түүнтэй үгсэн тохирсон бүлэг, цахим сүлжээг илрүүлэн шалгаж байна. Тухайн иргэд нь "Facebook", "Whatsapp" цахим сүлжээг ашигладаг, тухайн цахим сүлжээгээр бусадтай харилцан эмэгтэйчүүдийг зураг болон бусад мэдээллийг нь танилцуулснаар худалдаалдаг болох нь тогтоогдсон. Улмаар гэмт	80

					хэргийн нөхцөл байдлыг харгалзан хууль бус үйл ажиллагааг нь саармагжуулах, нөлөөлөх ажлыг зохион байгуулан, холбогдох шалгалтын ажлыг үргэлжүүлж байна. ЦЕГ-ын Эрүүгийн цагдаагийн албанаас цахим орчинд үйлдэгдэж буй хүн худалдаалах гэмт хэргийн талаар мэдээ, мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, хяналт тогтоох зорилгоор Sumbee програмыг ашиглан цахим орчинд олон удаа хууль бус зар мэдээ оруулсан фейсбүүк цахим хаягийг устгуулах хариу арга хэмжээ авахаар Кибер гэмт хэрэгтэй тэмцэх газраар дамжуулан хууль бус зар нийтэлж буй хуурамч хаягийн мэдээллийг “Харицлаа холбооны зохицуулах хороо”-руу уламжлуулахаар 11е/18563 дугаартай албан бичгээр “Sanhuu 2025 Naidvartai, Margad Gunbileg, Sarnai Sarnai, гэх цахим хаяг болон грүпп, 11е/19192 “Haluna Haluna, Sanhuu ugii avii 2025, Sanhuu 2025” гэх цахим хаяг болон грүпп, 11е/19653 дугаартай албан бичгээр “Anu Anu, Учка Учка, Medusa Etses” гэх цахим хаяг болон грүппийг “Мета” компанид уламжлуулан устгуулах ажлыг зохион байгуулж байна. ЦЕГ-ын Урьдчилан сэргийлэх албанаас хүүхдийн эрүүл мэнд, бие махбод, оюун санаа, ёс суртахууны хөгжил, төлөвшилд сөрөг нөлөө үзүүлэхүйц цахим тоглоом, хүүхдэд хортой агуулга, садар самуунд уруу татсан болон бусад гэмт хэрэгт өдөөн хатгасан шинжтэй 501 линк хаягийг устгуулахаар Харилцаа, холбооны зохицуулах хороонд албан бичиг хүргүүлж, 282 линк устгууллаа.	
--	--	--	--	--	--	--

2.5	Хүн худалдаалах, бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээ зохион байгуулах (ХХТХ-ийн 5.7)	Зохион байгуулсан нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээ	ЦЕГ	ТЕГ	ЦЕГ-ын Эрүүгийн цагдаагийн албанаас Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт нууц далд аргаар үйлдэгдэж байгаа ЭХТА-ийн 13.1 дүгээр зүйл Хүн худалдаалах, ЭХТА-ын 12.3 дугаар зүйл бэлгийн мөлжлөг, ЭХТА-ийн 12.6 дугаар зүйл биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын алба хаагчдад энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, илрүүлэх арга тактикийн мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх, энэ төрлийн гэмт хэргийн хохирогч нарын зөрчигдсөн эрхийг хангах чиглэлээр “Цөөвөр” нэгдсэн арга хэмжээг 2 сарын хугацаанд зохион байгуулах төлөвлөгөө, удирдамжийг Эрүүгийн цагдаагийн албаны дарга, Нийслэлийн Цагдаагийн Удирдах газрын дарга нар 2025 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр хамтран баталсан. “Цөөвөр” нэгдсэн арга хэмжээг 2 сарын хугацаанд хэрэгжүүлэн , зохион байгуулж, үр дүнг энэ оны 06 дугаар сарын 26-ны өдөр тооцож, ажилласан. Мөн энэ төрлийн гэмт хэргийн нөхцөл байдлыг хяналтад авах зорилгоор нийслэлийн хэмжээнд “Сүлжээ” хэсэгчилсэн арга хэмжээг 1 сарын хугацаанд зохион байгуулахаар энэ оны 09 дүгээр сарын 23-ны өдөр Албаны даргаар төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг ханган оны 11 дүгээр сарын 10-ны өдөр үр дүнг тооцож ажилласан. Дээрх 2 арга хэмжээний хүрээнд цаашид энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэхэд хамтран ажиллах иргэдийн судалгааг гаргаж, 11 хэргийг илрүүлж, 5 хэргийг эрүүгийн хэрэг үүсгэн яллагдагчаар татсан.	100
-----	--	---	-----	-----	--	-----

					Тагнуулын байгууллагаас ЭЦА-тай хамтран хүн худалдаалах, бэлгийн мөлжлөгийн хэлбэрээр үйлдэгдэх гэмт хэргийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээний төлөвлөгөө батлуулан 2025 оны 04 дүгээр сараас ЭЦА-ны Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэстэй хамтран судалгаа, хяналт, шалгалтын ажлуудыг хэрэгжүүлж байна. Биеэ үнэлэхийг зохион байгуулдаг байж болзошгүй 2 зочид буудал, 2 караокег тус тус тогтоон шалгаж байна. Хүн худалдаалах, бэлгийн мөлжлөг болон биеэ үнэлэлтийг зохион байгуулж, улмаар Монгол Улсын иргэдийг БНХАУ-д байх тус гэмт хэргийг зохион байгуулж буй иргэд, үгсэн тохирсон бүлэгт хил дамнуулан худалдаалдаг байж болзошгүй Монгол Улсын иргэд, түүний хууль бус үйл ажиллагаандаа ашиглаж буй цахим хаягийг илрүүлж, шалгах ажлыг бие даан зохион байгуулж байна.	
2.6	Монгол Улсад ажиллаж буй гадаад улсын иргэдийн хүн худалдаалах болон албадан хөдөлмөрлүүлэх гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хамтарсан хяналт шалгалтыг зохион байгуулах (ХХТгХ-ийн 5.9, 5.10)	Хамтарсан хяналт шалгалт	ГБХНХЯ, ГИХГ, ЦЕГ	ТЕГ	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас гадаадаас ажилтан авч ажиллуулж буй аж ахуйн нэгж байгууллагуудын гадаад ажилтны хөдөлмөр эрхлэлтэд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай 08-07/16 дугаартай удирдамж, шалгах асуумжийг Салбарын улсын ерөнхий байцаагчаар батлуулан, хяналт шалгалтын ажлыг эхлүүлээд байна. ГИХГ-аас ГХУСА33АА-ны даргын 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн А/18 дугаар тушаалаар гадаадаас ажилтан авч ажиллуулж буй аж ахуйн нэгж байгууллагуудад хяналт	70

					шалгалт хийх үүрэг бүхийн ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсгийг Гадаадын иргэн харьяатын газрын төлөөлөл ахлан Эрүүгийн цагдаагийн алба, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын алба, Тагнуулын ерөнхий газар, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны төлөөлөл гишүүдээр нь ажиллаж байна. Уг тушаалын хүрээнд “Хяналт шалгалтаар ажиллах тухай” удирдамжийг батлуулахаар холбогдох ажиллагааг хийж гүйцэтгэж байна. Түүнчлэн хяналт шалгалтын явцад иргэний мэдээллийг Тагнуулын байгууллагатай хамтран шалгаж, Сьерра Леон Улсын 7 иргэнийг албадан хөдөлмөрлүүлэх гэмт хэрэгт өртсөн болохыг тогтоож, тус асуудлыг чиг үүргийн хүрээнд цагдаагийн байгууллагад шилжүүлсэн. Цагдаагийн байгууллагаас дээрх хэрэгт Эрүүгийн хуулийн 13.13 дугаар зүйлд зааснаар эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж байна.	
2.7	Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр олон нийтэд мэдээлэл түгээх зорилгоор подкаст бэлтгэж хүргэх (ХХТХ-ийн 6.6.2)	Түгээсэн подкаст	ХЗҮХ	Дэд зөвлөлийн гишүүд	Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр олон нийтэд мэдээлэл түгээх зорилгоор NLI подкастын тусгай дугаарыг Хүйсийн тэгш эрх төвтэй хамтран “Хүн худалдаалах гэмт хэрэг: насанд хүрээгүй хохирогч” сэдвээр бэлтгэж олон нийтэд хүргэлээ. ХХЕГ: “Хүүхдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхэд хяналт тавих журам”-ыг олон нийтэд сурталчилах ажлын хүрээнд “Хилчин хүү, Шалгагч охин” сэдэвт контентыг Хил хамгаалах	90

					байгууллагын цахим хуудсаар дамжуулан олон нийтэд хүргэсэн. Замын-Үүд авто замын боомтод хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх агуулга бүхий 30.000 ширхэг хавчуургыг тарааж, 6 ширхэг зурагт самбарыг байрлуулсан. Хууль зүйн туслалцааны төвөөс Хууль зүйн туслалцааны төвөөс хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх зорилгоор богино хэмжээний 1 видео (рийл) бэлтгэн, байгууллагын цахим хуудас болон фэйсбүүк хуудсаар дамжуулан олон нийтэд түгээн ажиллаж байна. Нийт хандалт 2910 байна. Мөн 2025 оны 09 дүгээр сарын 17, 22-ны өдрүүдэд зохион байгуулсан сургалт, хэлэлцүүлгийн үеэр Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийг даган гарсан, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн А/399 дугаар тушаалын хавсралт “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид хууль зүйн туслалцаа үзүүлэх журам”-ыг танилцуулж, холбогдох мэдээллийг хүргэлээ. Тус үйл ажиллагаа нь нийгмийн хамгааллын алба хаагч, мэргэжилтнүүдийн ур чадварыг дээшлүүлэх зорилготой байсан бөгөөд Хууль зүйн туслалцааны төвийн Мэргэжил, арга зүйн хэлтсийн дарга А.Амарсайхан оролцож, журмын хэрэгжилт болон хууль зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагааны талаар мэдээлэл өгсөн. Уг сургалт, хэлэлцүүлэгт нийт 100 гаруй албан хаагч хамрагдсан. Улсын бүртгэлийн ерөнхий газраас Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хүн худалдаалах гэмт	
--	--	--	--	--	---	--

					хэргийн талаар албан хаагчдад мэдээлэл хүргэх зорилгоор 62 удаагийн арга хэмжээг зохион байгуулж, нийт 259 алба хаагчийг хамрууллаа. ССАЖЗЯ-аас Соёлын тухай хуулийн 39.5 дахь заалтын хэрэгжилтийг хангаж соёлын салбарын хэмжээнд дайн тулаан, хүчирхийлэл, гэмт хэрэг, садар самууныг сурталчилсан соёлын үйл ажиллагаа эрхлэхгүй байхад хяналт тавин ажиллаж байна. 21 аймгийн СУАЖЗГ, соёлын байгууллагууд нь цахим орчинд үйлдэгдэж буй хүн худалдаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх агуулга бүхий 4 сэрэмжлүүлэг, постер бэлтгэн цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулж иргэд, олон нийтэд сурталчилсан. Залуучуудын хөгжил, оролцоог нэмэгдүүлэх, шийдвэр гаргах түвшинд дуу хоолойг хүргэх зорилгоор НҮБ-ын Хүн амын сан, залуучуудын хөгжлийг дэмжих чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран 2018 оноос эхлэн жил бүр “Залуучуудын хөгжлийн сарын аян”-г орон даяар зохион байгуулдаг уламжлалтай. Тус аяны хүрээнд хүн амын хамгийн чухал бүлэг болох залуучуудын хөгжлийг дэмжихэд төрөөс баримтлах бодлого, хөтөлбөрийг танилцуулах, 21 аймаг, 9 дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй Залуучуудын хөгжлийн төвийн үйлчилгээг залууст сурталчлах, залуучуудын санал бодлыг сонсох, төр, иргэний нийгэм, олон улсын байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах олон талт нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулдаг онцлогтой. Энэ жилийн хувьд “Залуучуудын хөгжлийн сарын аяныг” 6 дахь жилдээ зохион байгуулж байгаа бөгөөд улсын хэмжээнд "Эерэг хандлага-	
--	--	--	--	--	--	--

					Идэвхтэй залуучууд" нөлөөллийн аяныг зохион байгуулахаар нэгдсэн удирдамжийг хүргүүлж тайлант хугацаанд 2,418 залуучуудад Хорт зуршлаас урьдчилан сэргийлэх, Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, Эерэг хандлагыг түгээн дэлгэрүүлж ажилласан.	
2.8	Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр зам тээвэр, хүнд үйлдвэрийн салбарын албан хаагчдад зориулсан сургалт зохион байгуулах (ХХТХ-ийн 6.6.10)	Сургалтын тоо Оролцогчдын тоо (хүйсээр) Сургалтын үр дүн (чанараар)	ГХУСАЗЗАА, АҮЭБЯ	ОУБ, ТББ	“Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь” төслийн хүрээнд “Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн Зорчигч тээврийн албаны албан хаагчдын хүн худалдаалах гэмт хэргийн талаарх мэдлэг, ойлголтыг нь дээшлүүлэх зорилгоор “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг таньж, илрүүлэх нь” сургалтыг 2025 оны 05 дугаар сарын 28-30-ны өдрүүдэд зохион байгууллаа. Сургалтад УБТЗ ХНН-ийн 135 (эр-16, эм-116) албан хаагч хамрагдлаа. Аж үйлдвэр, эрдэс баялагийн яамнаас Жеңдэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аяны хүрээнд хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалтыг дотооддоо зохион байгуулж, нийт 55 алба хаагч (эрэгтэй-30, эмэгтэй-25)-ийг хамрууллаа.	80
2.9	Кибер орчинд үйлдэгдэж буй хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч (хүүхэд) төвтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа” сургалт зохион байгуулах (ХХТХ-ийн 6.6.10)	Сургалтын тоо Оролцогчдын тоо (хүйсээр) Сургалтын үр дүн (чанараар)	ГХУСАЗЗАА	УЕПГ, ЦЕГ, ОУБ, ТББ	Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах төслийн хүрээнд “Кибер орчныг ашиглаж үйлдсэн хүн худалдаалах гэмт хэргийн мөрдөн шалгах ажиллагаа” бүсчилсэн сургалтыг 2025 онд зохион байгуулж, нийт 356 (эр-277, эм-79) мөрдөгч, прокурорыг хамрууллаа.	100
2.10	Хилийн боомтын албан хаагчдын хүн худалдаалах гэмт хэргийн талаарх мэдлэг ойлголтыг дээшлүүлэх, энэ төрлийн	Сургалтын тоо Оролцогчдын тоо (хүйсээр)	ХХЕГ, ГИХГ	Салбар дундын хамтарсан баг	Монгол Улсын Засгийн газар болон Америкийн Нэгдсэн Улсын Төрийн департаментын байгуулсан “Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь” төслийн хүрээнд:	100

	гэмт хэргийн хохирогчийг таньж, илрүүлэх сургалт зохион байгуулах (ХХТХ-ийн 6.6.10)				1. Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь хилийн хяналтын байгууллагын албан хаагчдад зориулсан Хүн худалдаалах гэмт хэргийн ойлголт, Хүүхдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхэд баримтлах журмын талаарх сургалтыг 2025 оны 01 дүгээр сарын 09, 10-ны өдрүүдэд зохион байгуулж, нийт 123 (эр-72, эм-51) албан хаагчийг хамруулав. 2. 2025 оны 06 дугаар сарын 26, 27-ны өдөр Баян-Өлгий аймгийн хилийн боомтын байгууллагуудын албан хаагчдад зориулсан “Хүн худалдаалах гэмт хэргийн ойлголт, онцлог” сургалтыг зохион байгуулж, хүн худалдаалах гэмт хэргийн нөхцөл байдал, чиг хандлага, урьдчилан сэргийлэх, илрүүлэх, хилийн боомтуудын өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага, Монгол Улсын хилээр хүүхэд нэвтрүүлэхэд анхаарах асуудал болон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хэрэглэсэн хүнд илрэх шинж тэмдгийн талаар ойлголтын талаар мэдээлэл өглөө. Сургалтад нийт 36 (эр-24, эм-12) алба хаагч хамрагдлаа. 3. "Хилийн боомтын байгууллагын алба хаагчдыг чадавхжуулах" сургалтыг 2025 оны 08 дугаар сарын 17-ны өдөр Өмнөговь аймгийн Гашуунсухайт боомтод зохион байгуулж, хилийн хяналтын байгууллагын 68 алба хаагчийг хамрууллаа. Сургалтаар хүн худалдаалах гэмт хэргийн тухай ойлголт, чиг хандлага, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үйл ажиллагаа,	
--	---	--	--	--	--	--

					хүүхдийн эрх, хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, хил дээрх дамжин өнгөрүүлэх ажиглалтын үйл ажиллагаа болон хүүхдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхэд баримтлах журмын хэрэгжилтийн талаар тус тус мэдээлэл өглөө. 4. “Зорчигчийг хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд хамтын ажиллагааг бэхжүүлэх” сургалтын хүрээнд “Хүн худалдаалах гэмт хэргийн нөхцөл байдал, Хүүхдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхэд хяналт тавих журам” сэдвээр Сэлэнгэ аймгийн Цагдаагийн газар, Гааль, Гадаадын иргэн харьяатын хэлтэс, Хилийн цэргийн 0101 дүгээр анги, Тагнуулын хэлтсийн төлөөллөөс бүрдсэн нийт 40 ажилтан, алба хаагчдад сургалтыг танхимаар зохион байгуулсан. Тагнуулын байгууллагаас бэлтгэсэн хүний наймаа, хүн хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлье зурагт хуудас болон бусад хэвлэмэл материалыг нисэх буудал, төмөр зам, авто замын улсын чанартай хилийн боомтуудад түгээсэн.	
2.11	Хүн худалдаалах, бэлгийн мөлжлөгийн хохирогч төвтэй, хүүхдэд ээлтэй арга зүйг эзэмшүүлэх сургалт зохион байгуулах (ХХТХ-ийн 6.6.10)	Сургалтын тоо Оролцогчдын тоо (хүйсээр) Сургалтын үр дүн (чанараар)	Салбар дундын хамтарсан баг	ДХИС, ШШЕГ, ОУБ	ГХУСА33АА-наас Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь төслийн хүрээнд Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч төвтэй, хүүхдэд ээлжтэй форензик ярилцлагын арга зүй” сэдэвт сургалтыг 2025.06.16, 17-ны өдрүүдэд зохион байгуулж, сургалтад Мөрдөн байцаах албаны Хүүхдийн эсрэг болон хүүхдээс үйлдсэн гэмт хэргийн мөрдөх хэлтэс, Кибер гэмт хэрэгтэй газар, төв, орон нутгийн цагдаагийн газрын	100

					хүүхдийн гэмт хэрэг мөрдөх чиг үүргийн 86 албан хаагчийг хамрууллаа.	
2.12	“Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхдэд өмгөөллийн үйлчилгээ үзүүлэхэд анхаарах асуудал” сургалтыг зохион байгуулах (ХХТтХ-ийн 6.6.10)	Сургалтын тоо Оролцогчдын тоо (хүйсээр) Сургалтын үр дүн (чанараар)	ХЗТТ	-	Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлэн уг сургалтыг зохион байгуулах боломжгүй болсон.	0
2.13	Албадан хөдөлмөрлүүлэх гэмт хэргийн мөрдөн шалгах ажиллагаа, түүнд тавих прокурорын хяналт сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулах (ХХТтХ-ийн 6.6.10)	Хэлэлцүүлэг зохион байгуулсан эсэх Оролцогчдын тоо	УЕПГ	-	Улсын ерөнхий прокурорын газрын дэргэдэх Сургалт судалгааны хүрээлэнгээс 2025 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр “Хөдөлмөрлөх эрхийн олон улсын гэрээ, конвенц” сэдэвт сургалтыг цахимаар зохион байгуулж, “Олон улсын хэмжээ ба албадан хөдөлмөр”, “Олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээ ба хүүхдийн хөдөлмөр” сэдвээр, мөн Нийслэлийн прокурорын газраас “Албадан хөдөлмөрлүүлэх гэмт хэрэг болон хүүхдээр тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэх гэмт хэргийн нөхцөл байдал, мөрдөн шалгах ажиллагаанд анхаарах асуудал” сэдвээр сургалт, мэдээлэл хийсэн.	100
2.14	Хүүхдийн эрхийн улсын байцаагч, хүүхдийн эрхийн хууль зүйн хороонд зориулсан “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхдийн хууль ёсны төлөөлөгчөөр оролцох нь” гарын авлага боловсруулах (ХХТтХ-ийн 6.6.4)	Боловсруулсан гарын авлага	УЕПГ	ХГБХХЕГ	Улсын ерөнхий прокурорын газраас 2025 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газартай хамтран хүүхдийн эрхийн улсын байцаагч, хүүхэд хамгааллын мэргэжилтэн, сум хорооны хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч зэрэг нийт 815 албан хаагчийг цахимаар оролцуулан “Хууль ёсны төлөөлөгчийн эрх, үүрэг, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд анхаарвал зохих асуудал” сэдвээр сургалт хийсэн. “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хууль ёсны төлөөлөгчөөр оролцох нь” гарын авлагын боловсруулалт хийгдэж байна.	70

					Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газраас Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн давтан, мэргэшүүлэх сургалтын хүрээнд Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн гарын авлагыг бэлтгэсэн. Уг гарын авлагад Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, болон бусад дүрэм, журам, стандартыг оруулсан бөгөөд хууль ёсны төлөөлөгчөөр ажиллахтай холбоотой хууль, дүрэм журмыг оруулсан. Мөн тус сургалтын явцад “Хүүхдийн эрхийн улсын байцаагч Эрүүгийн болон Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хууль ёсны төлөөлөгчөөр ажиллахад анхаарах асуудал” сэдвээр Хүчирхийллийн эсрэг үндэсний төвөөс чадавхжуулах сургалт орж, тус төвөөс 2023 онд гаргасан “Хууль ёсны төлөөлөгчөөр ажиллах нь” гарын авлагыг оролцогч нарт тараан мэдээлэл түгээсэн.	
2.15	Монгол Улсаас гадаад улсад суух ЭСЯ, КГ, ДТГ-т шинээр томилогдсон албан хаагчдад зориулсан сургалт зохион байгуулах (ХХТтХ-ийн 6.6.10)	Сургалтын тоо Оролцогчдын тоо (хүйсээр)	ГХЯ	ТЕГ, ТББ, ОУБ	Гадаад харилцааны яамнаас Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийг даган гарсан шинэчлэн найруулан батлуулсан журмуудыг танилцуулах улмаар гадаад харилцааны болон Гадаадын иргэн, харьяатын газрын алба хаагч, мэргэжилтнүүдийн ур чадварыг дээшлүүлэх сургалтыг 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр зохион байгууллаа. Сургалтад гадаад харилцааны болон Гадаадын иргэн, харьяатын газрын хяналтын 32 байцаагч танхимаар оролцож, хилийн чанадад суугаа Дипломат төлөөлөгчийн газрын 30 алба хаагч цахимаар хамрагдлаа. Түүнчлэн 2025 оны 06 дугаар 06-ны өдөр Эрүүгийн цагдаагийн албаны зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн	100

					Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тасагтай хамтран шинээр ДТГ-уудад томилогдсон нийт албан хаагчдад зориулсан сургалтыг зохион байгуулав. Улсын бүртгэлийн байгууллагаас Улсын бүртгэлийн ерөнхий хууль, иргэний бүртгэлийн тухай хууль, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн дагуу гадаадын иргэнтэй холбоотой 596 бүртгэлийг хөтөлж, иргэний улсын бүртгэлийн үйлчилгээг 1227 иргэнд үзүүлж, 123 иргэний үрчлэлтийн бүртгэлийг хийлээ. Мөн гадаадын иргэн, харьяалалгүй иргэний улсын бүртгэлд бүртгүүлэх хүсэлт ирүүлсэн 600 иргэнд заавар, зөвлөгөө өгч ажилласан.	
2.16	Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч төвтэй, хүүхдэд ээлтэй арга зүйг ДХИС-ийн мэргэжлийн тэнхимийн хичээлийн хөтөлбөрт тусгах	Агуулгад туссан хичээлийн хөтөлбөр	ДХИС	ГХУСАЗЗАА, ОУБ	ДХИС-иас 2025 оны 5 дугаар сард Азийн сангийн төслийн ажилтнуудтай албан уулзалт хийж, цагдаагийн алба хаагчийг бэлтгэж байгаа сургалтын хөтөлбөрийн хүний эрхийн агуулгыг нэмэгдүүлэх, хохирогч төвтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах чадвар эзэмшүүлэх, хандлага төлөвшүүлэх агуулга тусгах, цаашид хамтран ажиллах чиглэлээр санал солилцсон. Азийн сангаас хэрэгжүүлсэн төслийн хүрээнд боловсруулсан хүн худалдаалах, бэлгийн мөлжлөг, авлигын гэмт явдалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлийн 95 нэр төрлийн 168 ширхэг ном, товхимол, судалгааны тайланг тус байгууллагад хүсэлт тавьсны дагуу хүлээн авч, Их сургуулийн төв номын санд байршуулж, сургалт, судалгааны эргэлтэд оруулсан.	50
2.17	Өсвөрийн клубуудын үйл ажиллагааг дэмжиж, хамтран ажиллах замаар	Дэмжлэг үзүүлсэн клуб,	БЕГ	Анбаунд Монгол ТББ	Боловсролын ерөнхий газраас өсвөрийн клубуудын үйл ажиллагааг дэмжих зорилгоор ""Өмгөөллийн Алтаргана хуулийн товчоо"-той	100

	хүн худалдаалах, бэлгийн мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах (ХХТтХ-ийн 5.6.1)	түүний үйл ажиллагаа			хамтран 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдрөөс 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдрүүдийн хооронд Нийслэлийн ерөнхий боловсролын 13 сургуулийн ахлах болон дунд ангийн сурагчдад "Эрх зүй ба өсвөр нас" сэдвээр сургалт зохион байгуулсан. Тухайлбал, Баянзүрх дүүргийн 48, 33, 84, 111, 30, 69, 55, 14, 44, 53, 68, 92-р сургуулийн нийт 1560 сурагч хамрагджээ. Анбаунд Монгол ТББ-аас Боловсролын ерөнхий газартай хамтран Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь төслийн хүрээнд нийт 87 өсвөрийн клубийг ерөнхий боловсролын 66 сургууль, Мэргэжлийн сургалт үйлдвэрийн төв болон Дэлхий зөн Монголын олон улсын байгууллагын орон нутгийн салбарт байгуулж, 204 чиглүүлэгч багш, 155 өсвөрийн чиглүүлэгч бэлтгэж, чиглүүлэгчүүдээр дамжуулан 1976 суралцагчид тодорхой сургалтыг зохион байгууллаа. Дээрх төслийн хүрээнд Баянгол дүүргийн 13 дугаар сургууль, Баянзүрх дүүргийн Амгалан цогцолбор сургууль, 79 дүгээр сургууль, Сонгонохайрхан дүүргийн 104 дүгээр сургууль, Сүхбаатар дүүргийн Эрдмийн хөтөч сургуулиудад 2025 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр "Хүүхэд хөгжлийн клуб"-ыг нээж, кабинетыг тохижуулан хүлээлгэн өглөө. Энэхүү төслийг хэрэгжүүлснээр суралцагчдын 76.3% нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлж, 66.7% нь бусадтай эергээр харилцаж, дэмждэг үзүүлж, 61.7% нь ангийн дүрмээ хамтдаа боловсруулж, 59.8% ангийн дүрэм журмаа	
--	--	----------------------	--	--	---	--

					судалж, өдөр тутамдаа мөрдлөг болгож, 56.4% өөрт хэрэгтэй дэмжлэгээ хаанаас, хэнээс асуух аа мэддэг болсон үр дүнгүүд гарч байна. Төслийн хүрээнд 2024-2025 оны хичээлийн жилд Дэлхийн Зөн Монгол ОУБ-тай хамтран тус байгууллагын орон нутгийн хөтөлбөрүүдээр дамжуулан клубын үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор нийт 43 чиглүүлэгч багшийг шинээр бэлтгэсэн. Эдгээр багш нар нь Улаанбаатар хотын Сонгинохайрхан, Баянгол, Баянзүрх, Багануур дүүрэг болон Төв, Сэлэнгэ, Хөвсгөл, Говь-алтай аймгуудаас ирж сургалтад хамрагдан “Цахим орчин дахь хүүхдийн аюулгүй байдал” хөтөлбөр, “Өөрчлөлтийн төлөөх дуу хоолой” хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүйд суралцсан. “Ухаалаг хөтөч”, “Өөрчлөлтийн төлөөх дуу хоолой”, “Цахим орчин дахь хүүхдийн аюулгүй байдал” хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлсэн 15 клубийн чиглүүлэгч багш нар сайн дураар хөтөлбөрийг дахин хэрэгжүүлэхээ мэдэгдэж манай байгууллагаас шаардлагатай дэмжлэг, тусалцааг үзүүлсэн. Нийслэлийн Боловсролын Газар, Дэлхийн Зөн Монгол ОУБ-тай хамтран Хичээлээс Гадуурх Үйл Ажиллагааг Сурталчлан Таниулах Өдөрлөгийг зохион байгуулсан. НҮБ-ын Хүн амын сангийн дэмжлэгтэйгээр "Ээлтэй сургууль" төслийг Баян-Өлгий, Ховд, Завхан, Хөвсгөл, Булган, Өвөрхангай, Дархан-Уул, Баянхонгор, Өмнөговь, Дорнод аймаг, нийслэлийн Баянзүрх, Сүхбаатар дүүргийн нийт 33 ерөнхий боловсролын сургуульд үргэлжлэн	
--	--	--	--	--	---	--

					хэрэгжиж "Үе тэнгийн сургагч бэлтгэх" сургалтыг зохион байгуулж, сургалтад 10-12 дугаар ангийн 400 суралцагч оролцсон. Энэхүү төсөл нь сургууль бүхлээрээ ажиллах арга хандлагаар хамтран ажиллаж, 29000 суралцагч, 3100 удирдлага болон багш ажилтан нарт хүрч ажиллаж байна. Мөн Эрүүл мэндийн хөгжлийн төв, Монголын хүүхдийн анагаахын академитай хамтран нийслэлийн ерөнхий боловсролын 35, 49, 57, Эрдмийн өргөө, 93, 96 дугаар сургуулийн 30 сурагчийг үндэсний сургагч бэлтгэн нийслэлийн 200 сурагчийг "Өсвөр үеийн бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд"-ийн үе тэнгийн зөвлөгчөөр бэлтгэлээ. "Хүүхдэд аюулгүй цахим орчин" аяны хүрээнд аймаг, нийслэлийн 33 сургуулийн 452 нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, эцэг эх, асран хамгаалагч нарт сургалт зохион байгуулсан. Сүхбаатар аймгийн ЕБС-ийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нарт суралцагчийн хөгжил, төлөвшил, хамгаалал, аюулгүй байдлыг хангах, үйлчилгээг сайжруулахад арга зүйн дэмжлэг үзүүлэх" сургалтыг 28 хүнд зохион байгуулсан. ЕБС-ийн хүүхэд хамгааллын үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэхэд, "Эрүүл аюулгүй сургууль"-арга хэмжээний хүрээнд орон нутгийн хамтын ажиллагаа, түншлэлийг сайжруулахад аймаг, нийслэлийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хөгжлийн хэлтсийн мэргэжилтэн, Боловсролын газар, хэлтсийн Хүүхэд хөгжил хамгаалал, тэгш хамран сургах боловсрол хариуцсан 60 мэргэжилтэнд сургалт зохион байгуулсан. ЕБС-ийн хүүхэд хамгааллын багийг чадавхжуулах үндэсний хэмжээний сургалтыг 953 нийгмийн ажилтанд Боловсролын орчин дахь хүүхдийн	
--	--	--	--	--	---	--

					эрх, хамгааллын чиглэлээр баримталж буй бодлого, хууль журам, кейс менежмент, суралцагчийн нийгэм сэтгэл зүй болон эрүүл мэнд, сургалтын байгууллагын аюулгүй орчин, үе тэнгийн дээрэлхэл,хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр сургалтыг зохион байгуулсан.	
Гурав. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах, шаардлагатай үйлчилгээ үзүүлэх, үнэлэх ажлын хүрээнд						
3.1	Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хамгааллын түр хамгаалах байрны үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагыг дэмжих (ХХТХ-ийн 9.5)	Үзүүлсэн дэмжлэг (төгрөг) Хамгаалсан хохирогч (хүйсээр)	ГХУСА33АА	-	ГХУСА33АА-аас Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил,үйлчилгээ худалдан авах тухай хуулий хүрээнд Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үзүүлж буй үйлчилгээг дэмжих зорилгоор тендер шалгаруулалтыг зарлаж, уг тендерт Хүйсийн тэгш, эрх төв төрийн бус байгууллага шалгаран 30,000,000 (гучин сая) төгрөгийг үйлчилгээ үзүүлэх гэрээг байгуулан ажиллаж байна.	100
3.2	Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид хууль зүйн үнэ төлбөргүй туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулах (ХЗТХ-ийн 6.1.2)	Хохирогчид үзүүлсэн хууль зүйн туслалцаа (хүйсээр)	ХЗТТ	ХГБХХЕГ	Хууль зүйн туслалцааны төв нь 2025 онд Хууль зүйн туслалцааны тухай хуулийн 6 дугаар зүйл болон Эрүүгийн хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д заасны дагуу хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч, холбогдогч нийт 40 хүнд үнэ төлбөргүй өмгөөллийн үйлчилгээ үзүүлсэн бөгөөд үүнээс хохирогч 13 (үүнээс насанд хүрээгүй 11 хохирогч багтсан), холбогдогч 27 хүнд үйлчилгээ үзүүлсэн байна. Эдгээр хэрэгт хамаарах нийт 9 хэргийг шийдвэрлэгдсэн бөгөөд үүнээс 5 хэрэг нь тухайн зүйлчлэлийн дагуу, 4 хэрэг нь зүйл анги өөрчлөгдөн шийдвэрлэгдсэн байна. Бусад үлдсэн 31 хэрэг нь одоогоор ажиллагаанд байгаа болно. Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газраас хүүхдийн тусламжийн 108 утасны	100

					үйлчилгээний төвд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхдийн дуудлага мэдээлэл 2025 онд 6 бүртгэгдэж, үүнээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд насанд хүрээгүй хохирогч 4 хүүхэд тогтоогдон 2025 оны 12 дугаар сарын 12-ны байдлаар Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ, түр хамгаалах байранд аюулгүй байдлын хамгааллын үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна. ХТЭТ ТББ-аас Эрүүгийн цагдаагийн газартай хамтран хүн худалдаалах 2 хэрэгт өмгөөллийн үйлчилгээ үзүүлж байна.	
3.3	Хүн худалдаалах, бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдэд ээлтэй өрөө байгуулах	Байгуулсан өрөө	ГБХНХЯ, ХГБХХЕГ	ГХУСАЗЗАА, ОУБ	Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь төслийн хүрээнд Дархан-Уул аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамагаллын газар байгуулсан Хүүхдэд ээлтэй өрөөтэй танилцаж, аймгийн Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны зарим гишүүдтэй уулзалт хийж үр дүн, ач холбогдлын талаар ярилцаж, туршлага судалсан. ХГБХХЕГ-ын дэргэдэх Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ, түр хамгаалах байр, СБД, ЧД, БЗД-ийн түр хамгаалх байрны орчин нөхцөлтэй танилцаж, хүүхдэд ээлтэй өрөөний хэрэгцээг тодорхойлсон. Энэ хүрээнд Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ, түр хамгаалах байр, Нийслэлийн ЧД, БЗД-ийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтсийн дэргэдэх түр хамгаалах байранд хүүхдэд ээлтэй өрөөг (3) иж бүрэн тохижуулж, 2025 оны 12 дугаар сарын 22-ны өдөр хүлээлгэн өгсөн. ГХУСАЗЗАА-аас Дэлхийн зөн Монгол ОУБ-тай хамтран Өвөрхангай аймгийн Хүүхэд, гэр бүлийн	100

					хөгжил, хамгааллын газрын дэргэд Хүүхдэд ээлжтэй өрөөг тохижуулан, 2025 оны 06 дугаар сарын 01-ний өдөр ашиглалтад орууллаа.	
Дундаж үнэлгээ						82.75

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

ДЭД ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



Т.АМАРЖАРГАЛ

2025 оны 12 сарын 28 өдөр